



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 03 сарын 19 өдөр

Дугаар А/160

Булган сум

Гүйцэтгэгчид гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааны XIX/08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан Ойн хортны судалгааны ажил (ой бүхий сумдад 800,000 га талбайд)-ыг гүйцэтгэх гүйцэтгэгчээр шалгарсан “Их оргил ой” ХХК-тай 56,000,000 (тавин зургаан сая) төгрөгөөр гэрээ байгуулж, холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу хяналт тавьж, хүлээн авахыг Байгаль орчны газар (А.Гантөмөр)-т үүрэг болгосугай.

2. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандартын дагуу гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг “Их оргил ой” ХХК-ийн захирал (Б.Мөнхбаатар)-д үүрэг болгосугай.

3. Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Б.Бумцэнд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



Аймгийн Засаг даргын 2025 оны
 03 дугаар сарын 14-ны/ний өдрийн 4/160 дүгээр
 захирамжийн хавсралт

д/д	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	2	3	4
1	Ажил гүйцэтгэх хугацаа	Хуанлийн 120 хоног	А.Гантөмөр
2	Алданги	Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.2 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна	Б.Бумцэнд
3	Чанарын баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 5 хувь, чанарын баталгааг байршуулах банк, дансыг гэрээнд тусгана.	Б.Бумцэнд А.Гантөмөр